

Зарлал

Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2016 оны А/37дугаар тушаалаар баталсан "2016-2017 оны бакалаврын элсэлтийн шалгалтын журам"-д зааснаар 2016-2017 оны хичээлийн жилд дараах чиглэлийн бакалаврын хөтөлбөрт захиалагч агентлаг, байгууллагын алба хаагч болон иргэнийг элсүүлэн суралцуулна.

| № | Хөтөлбөрийн нэр, индекс | Шалгалтын чиглэл, босго оноо | | Нэмэлт шалгалт | Хугацаа |
|--|--|--|--|---|---------|
| | | Суурь | Хавсралт | | |
| 17-25 хүртэл насны, эрэгтэй, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэдийг элсүүлэх өдрийн сургалттай бакалаврын хөтөлбөр | | | | | |
| 1 | "Цагдаа-хууль сахиулах ажил" /D103201/ | Нийгмийн тухай мэдлэг Босго оноо: 400 | Математик, Гадаад хэл /сонгох/ Босго оноо: 400 | Эрүүл мэнд, Бие бялдар, Сэтгэл зүйн чиглэлээр нэмэлт шалгалт, сорил | 4 жил |
| 4 | Эрх зүй /D041201/ | Нийгмийн тухай мэдлэг Босго оноо: 400 | Математик, Гадаад хэл /сонгох/ Босго оноо: 400 | Нэмэлт шалгалт авахгүй | 4 жил |

Элсэхийг хүсэгч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

- Бүрэн дунд боловсролтой элсэхийг хүсэгч нь 2016 онд монгол хэл, бичгийн шалгалт өгч, 400 буюу түүнээс дээш оноо авсан байх;
- Сонгосон хөтөлбөрт хамаарах хичээлүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь 400 буюу түүнээс дээш байх;
- 2014, 2015, 2016 онд элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн, хүчин төгөлдөр батламжтай байх;
- Бакалавр зэрэгтэй элсэхийг хүсэгчийн хувьд дээрх шаардлага хамаарахгүй бөгөөд боловсролын зэргийн диплом, хавсралт хүчин төгөлдөр байх. Их сургуулийн Элсэлтийн шалгалтын комиссоос зохион байгуулсан суурь болон хавсралт шалгалт өгч, нийт онооны 60 буюу түүнээс хувийн үнэлгээ авсан байхыг тус тус шаардана.

Эрх зүй /D041201/ хөтөлбөрөөс бусад хөтөлбөрт элсэхийг хүсэгч иргэн дараах тусгай шаардлагыг хангасан байна.

- Эрэгтэй, 17-25 хүртэл насны, биеийн өндөр 168 см буюу түүнээс дээш;
- Нүүрний хэлбэр төрх зөв, ил харагдах 20X05мм-ээс том сорви, шивээсгүй, бие эрхтний гэмтэл согоггүй, эрүүл байх;

- “Цагдаа-хууль сахиулах ажил” хөтөлбөрөөс бусад хөтөлбөрт элсэхийг хүсэгч ял шийтгэлгүй байх(ял шийтгэлтэйд тооцох хугацаа өнгөрсөн байх);
- “Цагдаа-хууль сахиулах ажил” хөтөлбөрт элсэгч ял шийтгэгдэж байгаагүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар захиргааны шийтгэлийг эдэлж дууссанаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн байх;
- Захиалагч агентлаг, байгууллагын зан байдал, хандлага, ёс зүйн судалгаанд тэнцсэн байх;
- Нэмэлт шалгалт, Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалтад тэнцсэн байхыг тус тус шаардана.

Элсэхийг хүсэгч иргэн 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд Хууль сахиулахын их сургуулийн www.leu.gov.mn цахим хуудасны “Элсэлтийн цахим бүртгэл” холбоосоор зөвхөн нэг хөтөлбөрийг сонгож цахимаар бүртгүүлнэ. Элсэхийг хүсэгч алба хаагч холбогдох агентлаг, байгууллагын хүний нөөц, сургалтын асуудал хариуцсан нэгжээр уламжлан элсэн суралцах хүсэлтээ гаргах бөгөөд цахим бүртгэлд хамрагдахгүй.

Өдрийн сургалттай хөтөлбөрт элсэхийг хүсэгч иргэдийн сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна.

| № | Сонгон шалгаруулалт | Хугацаа | Тайлбар |
|---|--|---------------------------|---|
| 1 | Цахим бүртгэлд хамрагдах | 2016.04.01- 2016.06.15 | Цахим бүртгэлийн програмаас өгөгдөх зааварчлагын дагуу мэдээллээ бүрэн, үнэн зөв оруулсан байна. |
| 2 | Нэмэлт шалгалтад орох эрх бүхий элсэхийг хүсэгчдийг сонгон шалгаруулах | 2016.07.01- 2016.07.03 | Суурь болон хавсралт хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын онооны нийлбэрээр буурах эрэмбээр жагсааж, батлагдсан хяналтын тоог 30 хувиар нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны элсэхийг хүсэгчид нэмэлт шалгалтад орох эрхтэй болно. |
| 3 | Элсэхийг хүсэгч ял шийтгэлтэй эсэхийг шалгах | 2016.07.06-ны дотор | Ял шийтгэлтэй холбогдох тусгай шаардлагыг хангахгүй бол нэмэлт шалгалтад орох эрх олгохгүй, элсэхийг хүсэгчийн бүртгэлээс хасна. |
| 4 | Нэмэлт шалгалтад орох эрх олгох, шалгалтын хуудас баталгаажуулах | 2016.07.02- 2016.07.04 | Нэмэлт шалгалтад орох эрх олгосон элсэхийг хүсэгч Хууль сахиулахын их сургуульд биөчлэн ирж бүртгүүлнэ. 2016 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж шаардахгүй. |
| 5 | Эрүүл мэндийн үзлэг | 2016.07.04- 2016.07.06 | Эрүүл мэндийн үзлэгийг ХСИС-д зохион байгуулах ба эрүүл мэндээр тэнцэхгүй бол элсэхийг хүсэгчийн бүртгэлээс хасна. |

| | | | |
|----|--|---------------------------|---|
| 6 | Бие бялдрын шалгалт | 2016.07.06- 2016.07.08 | Бие бялдрын шалгалтад тэнцэхгүй бол элсэхийг хүсэгчийн бүртгэлээс хасна. |
| 7 | Сэтгэл зүйн сорил | 2016.07.09 | Сэтгэл зүйн сорилд тэнцэхгүй бол элсэхийг хүсэгчийн бүртгэлээс хасна. |
| 8 | Зан байдал, хандлага, ёс зүйн байдлыг судлах | 2016.08.20 хүртэл | Судалгаанд тэнцэхгүй бол элсэхийг хүсэгчийн бүртгэлээс хасна. |
| 9 | Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамруулах | 2016.07.25- 2016.08.25 | Хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгчид цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдана. Сургалтад бүрэн хамрагдаагүй тохиолдолд элсэхийг хүсэгчийн бүртгэлээс хасна. |
| 10 | Элсүүлэн суралцуулж, сонсогч цол олгох | 2016.08.25 | 2016-2017 оны хичээлийн жилийн I улирлын сургалт 2016 оны 08 дугаар сарын 25-наас эхэлнэ. |

Бие бялдрын шалгалтыг дараах шалгуураар авна. Элсэхийг хүсэгч "Хүч", "Тэсвэр", "Уян хатан", "Хурд", "Авхаалж самбаа" гэсэн бүх төрөлд заавал хамрагдах бөгөөд авсан оноо нь нийт авбал зохих онооны 50%-д хүрэхгүй тохиолдолд шалгалтад тэнцэхгүйд тооцно.

А. Эрэгтэй

Бакалаврын хөтөлбөрийн 4 жилийн сургалттай өдрийн ангид элсэхийг хүсэгч дээд боловсролтой иргэний сонгосон хөтөлбөрт хамаарах суурь ба хавсралт шалгалтыг 2016 оны 07 дугаар сарын 09-ний дотор зохион байгуулна.

Элсэхийг хүсэгч алба хаагч нэмэлт шалгалт, судалгаанд хамрагдахгүй бөгөөд холбогдох агентлаг, байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгжийн зөвшөөрөлгүй бол элсүүлэн суралцуулахгүй.

Эрх зүй /D041201/ хөтөлбөрт элсэхийг хүсэгчдээс нэмэлт шалгалт авахгүй бөгөөд элсэлтийн ерөнхий шалгалтын суурь ба хавсралт хичээлийн шалгалтын оноогоор буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

Жич: Элсэлтийн шалгалттай холбоотой бусад мэдээллийг Их сургуулийн www.leu.gov.mn цахим хуудаснаар элсэлтийн цахим бүртгэл" холбоосоор болон 89891566, 88023342 дугаарын утсаар лавлана уу.

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

